



**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ГАЗАРЗҮЙ,
ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНЫ ТҮҮХТ
60, 25 ЖИЛИЙН ОЙ**

**THE HISTORICAL 60th/25th ANNIVERSARY OF THE ESTABLISHMENT
OF THE INSTITUTE OF GEOGRAPHY AND GEOECOLOGY OF THE
MONGOLIAN ACADEMY OF SCIENCES**

**ШУА-ИЙН ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН ҮҮСГЭН
БАЙГУУЛАГДСАНЫ ТҮҮХТ 60, 25 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ХУРАЛ
АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА**

**CONFERENCE FOR THE HISTORICAL 60th/25th ANNIVERSARY CELEBRATION OF THE
ESTABLISHMENT OF THE INSTITUTE OF GEOGRAPHY AND GEOECOLOGY OF THE
MONGOLIAN ACADEMY OF SCIENCES WAS SUCCESSFULLY ORGANIZED**

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн (ГГХ) үүсгэн байгуулагдсан ойг энэ онд Монгол Улсын шинжлэх ухааны анхны төв байгууллага болох Судар бичгийн хүрээлэнд орчин цагийн Газарзүйн шинжлэх ухаан хөгжиж эхэлсний 98 жил, Газарзүй-Цэвдэг судлалын хүрээлэн байгуулагдсаны 60 жил, Геоэкологийн хүрээлэн байгуулагдсаны 25 жил, Газарзүй-цэвдэг судлалын хүрээлэнг үүсгэн байгуулагч Төрийн соёрхолт, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн академич, Ш.Цэгмид агсны 100 жил, Төрийн соёрхолт, цэвдэг судлаач, нэрт эрдэмтэн Н.Лонжид агсны 100 жилийн ойн хүрээнд түүхэн өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлсэн.



Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн үүсгэн байгуулагдсаны түүхт 60/25 жилийн ойн баярын хурал 1) Баярын мэндчилгээ, 2) “Монгол улсын үндэсний атлас 2022” бүтээлийн нээлт, 3) “Түүхэн 60/25 жил ба ирээдүй” гэсэн үндсэн гурван хэсэгтэй зохион байгуулагдсан.

Ойн баярын эрдэм шинжилгээний хурлыг ШУА-ын ГГХ-ийн захирал, доктор А.Дашцэрэн нээж, хүрээлэнгийн эрдмийн хамт олны ололт амжилт, цаашдын зорилго, хамтын ажиллагааны тухай танилцуулга хийв. Баярын хуралд УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, академич Д.Рэгдэл, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, доктор Д.Баттогтох нар мэндчилгээ дэвшүүлэв. Мөн ГГХ-тэй хамтран ажилладаг гадаадын байгууллагууд, тухайлбал, Жайка, ОХУ-ийн ШУА-ийн Сибирийн салбарын Байгалийн менежментийн Байгаль нуурын хүрээлэн, ОХУ-ийн ШУА-ийн Сибирийн салбарын В.Б. Сочавагийн нэрэмжит Газарзүйн хүрээлэн, ОХУ-ийн ШУА-ийн А.Н.Северцовын нэрэмжит Экологи хувьслын хүрээлэн, БНХАУ-ын ШУА-ын Газарзүйн шинжлэх ухаан ба байгалийн нөөцийн судалгааны хүрээлэн, Герман Улсын Аахены их сургууль, Норвеги Улсын Ослогын их сургуулийн төлөөллүүд оролцож, баярын мэнд хүргэв.



Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, академич Д.Рэгдэл нар мэндчилгээ дэвшүүлэв.

Хурлын завсарлагаанаар ГГХ-ийн түүхэн 60/25 жилийн ойд зориулсан фото зургийн үзэсгэлэнг дэлгэж, “Газарзүйчдийн мөрөөр”, “Экологи бидний амьдралд” зэрэг баримтад кинонуудыг ирсэн зочдод танилцуулав. Мөн салбарын төлөөллүүд судалгаа, шинжилгээнд ашиглагдаж буй орчин үеийн багаж, тоног төхөөрөмжийг үзүүлэн болгон бэлтгэж сонирхууллаа.



Фото зураг, багаж хэрэгслийн үзэсгэлэнг дэлгэж танилцуулав.



“Газарзүйчдийн мөрөөр”, “Экологи бидний амьдралд” зэрэг баримтад кинонуудыг нийтийн хүртээл болгов.

ГГХ-ийн түүхэн 60/25 жилийн ойг угтаж хийсэн томоохон ажлуудын нэг нь “Монгол Улсын Үндэсний Атлас” бүтээлийг бэлтгэх байв. Хурлын хоёрдугаар хэсэгт энэхүү бүтээлийн нээлтийг хийж, бүтээлийн ерөнхий редактор, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Д.Доржготов үг хэлэв. Бүтээлийн нээлтэд тусгайлан баяр хүргэж, Монгол Улсын Ерөнхийлөгч мэндчилгээ дэвшүүлснийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Боловсрол, шинжлэх ухаан, технологийн бодлогын зөвлөх, доктор Ч.Лодойравсал уламжлав. “Монгол Улсын Үндэсний Атлас” бүтээлийн редакцийн зөвлөлийн орлогч дарга, Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг

зохицуулах газрын дарга, доктор Д.Баттогтох бүтээлийн талаар товч танилцуулж, энэхүү бүтээл нь Монгол орны газарзүй, байгаль орчин, байгалийн нөөц, нөхцөл, хүн ам, нийгэм, түүх, соёл, эдийн засгийн холбогдолтой нийт 246 сэдэвчилсэн зургаас бүрдэх бөгөөд олон талт мэдээллийг агуулсан шинжлэх ухааны лавлагаа, мэдээллийн эх сурвалж болохыг онцлоод, бэлтгэл ажилд эрдэм шинжилгээний болон төрийн, төрийн бус 30 байгууллага, 140 гаруй хүний хүч хөдөлмөр шингэсэн бүтээл болохыг тодотгов. Илтгэлийн дараагаар бусад хүмүүсийн хамтаар нийт 13 нэр бүхий яамд, агентлагууд, хүрээлэнгүүд болон их сургуулиудын төлөөллүүдэд бүтээлийн дээжээс гардуулав.



БШУЯ-ны ШУТБИХХЗГ-ын дарга, доктор Д.Баттогтох “Монголын Үндэсний Атлас” бүтээлийн талаар товч танилцуулж, академич Д.Доржсготов академич Д. Рэгдэлд гардуулав.

“Түүхэн 60/25 жил & ирээдүй” хурлын арга хэмжээ буюу ГГХ-ийн түүхт 60/25 жилийн ололт, амжилтыг дүгнэн хэлэлцэх, ирээдүйд хүлээгдэж буй сорилт, стратеги, алсын хараа, хамтын ажиллагааны талаарх хэлэлцүүлгийг хурлын гуравдугаар хэсэгт өрнүүлж, ГГХ-ийн салбар тус бүрээр салбарын дарга нар холбогдох төр засгийн байгууллагын төлөөллүүдийн оролцоотой явуулав. Хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг эцэслэн ГГХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Б.Баяртунгалаг танилцуулснаар хурал өндөрлөж, ГГХ-ийн захирал, доктор А. Дашцэрэн хаалтын үгийг хэлэв.



Ололт, амжилт, сорилт, хамтын ажиллагааг өргөжүүлэх хэлэлцүүлэг.

Шинжлэх Ухааны Академийн Газарзүй, Геоэкологийн Хүрээлэнгийн 60/25 жилийн ойн баярын хуралд ГГХ-ийн 127 эрдэмтэн судлаачид, ажилчид, 59 ахмадууд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, БШУЯ, БОАЖЯ, ЗТХЯ,ЭЗХЯ, БХБЯ, ГЗБГЗЗГ, Нийслэлийн байгаль орчны газар, ШУА, түүний харьяа хүрээлэнгүүд, ШУТ сан, МУИС, МУБИС, ХААИС, ШУТИС, Ховд их сургууль, “Биллитон Глори” ХХК, ЖАЙКА, Зэрлэг амьтан хамгаалах төв, Мянганы сорил төсөл, Уур амьсгалын өөрчлөлт-хөгжил академийн 59 төлөөллүүд зэрэг нийт 268 хүн оролцсон болно.